



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/120.

Цагаантолгой

Баримт бичиг нягтлан шалгах комисс  
томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 24 дүгээр зүйлийн 24.1.7, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга- сумын Засаг даргын орлогч  
Нарийн бичиг- Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч  
Гишүүдэд – Төрийн захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Санхүүгийн албаны дарга  
Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

2. Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын ажлыг хууль тогтоомж, заавар, журмын дагуу чанартай хийж гүйцэтгэхийг комиссын бүх гишүүдэд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/42 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *Мергэл*  
Хянасан: *Ч. Азжаргал*  
Хувь: *2*  
Огноо: *2022.09.15*